

**НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг хүн амын бодит хэрэгцээнд тулгуурлан хүргэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, нийгмийн халамж, хамгаалал нь шаардлагатай бүлэгт хүрч очих, хүний суурь хэрэгцээг хангахын тулд нийгмийн ажил, үйлчилгээний дэд бүтэц болон нийгмийн ажлын мэргэжлийн хүрээ, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсоно гэж заасны дагуу Засгийн газрыг төлөөлж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулга хийлээ.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын "d.parliament.mn" цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа 2022 онд гарсан цар тахлын үед Япон улсаас манай улсад иргэдийн эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн системийг хийж өгч байсныг ашиглаж байгаа эсэх, нийгмийн ажилтан нь иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн ажилтан байх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар манай улсад нийгмийн ажилтны тогтолцоо олон жилийн өмнөөс хэрэгжиж эхэлсэн боловч нэгдмэл эрх зүйн орчин бүрдээгүй, удирдлага нь салангид байдгаас шалтгаалан мэргэжлийн нэгдсэн удирдлага дутмаг тул үйлчилгээний төрөл, хэлбэрийг тодорхой болгож, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг тусгах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр техникийн шинжтэй засваруудыг дурдан нэмэлт санхүүжилт, мэдээллийн сан бүрдүүлэх төсөв болон бусад хуулийн заалттай давхацсан байгааг анхаарч уялдаа холбоог хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нийгмийн ажилтны талаар бие даасан хуульгүй байгаа нь ямар асуудал үүсгэж байгаа, мэргэжлийн бус хүмүүс нийгмийн ажилтны чиг үүргийг хэрэгжүүлж байгааг зогсоох шаардлагатай мөн хуулиар салбар хоорондын уялдааг сайжруулах тал дээр анхаарах, манай улсад нийгмийн ажилтны үйлчилгээ авах шаардлагатай иргэдийн тоо, хэрэгцээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хуулийн төсөлд нийгмийн ажилтан нь мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ өгөх талаар орсон нь

оновчтой эсэх, мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл өргөн баригдвал энэ хуультай хэрхэн уялдах байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хүнд хагалгаа болон эмчилгээний дараа үзүүлэх шаардлагатай үйлчилгээг хангах, нэг цэгээс үйлчилгээ авах тогтолцоог уялдуулах, нийгмийн ажилтны үйлчилгээний стандарт, лицензийн асуудал, санхүүжилтийн тогтолцоог тусгах, Сангийн яамны оролцоог хангаж, салбар хоорондын уялдааг зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах ерөнхий боловсролын сургуульд хүүхдийн төлөвшлийн асуудлыг дангаар хариуцдаг нийгмийн ажилтан байх ёстой, үүнийг сургуулийн удирдах ажилтан хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр салбар хоорондын уялдаа холбоог дурдаж байгаатай адил нутаг дэвсгэрийн нийгмийн ажилтны уялдаа холбоог сайжруулахад анхаарах талаар асуулт асууж, хариулт авч, санал хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасны дагуу Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ